

Курсын тойм

Энэ курс нь Библийн хөрвүүлгийн үндсэн зарчмуудыг танилцуулдаг. Тус курсын ихэнх хичээлүүд нь Howard ба William Hendricks-ийн *Living by the Book* хэмээх алдартай сурах бичигт үндэслэгдэж бичигдсэн. Хэрэв та энэ номыг унших боломжтой бол тухайн хичээл дээр заасан зарчмуудыг хэрэгжүүлэх дасгал ажлуудыг болон зарчим бүр дээрх хэлэлцүүлгийг олж харах болно. Гэхдээ энэ курсэд сурах бичиг шаардлагагүй. Шаардлагатай бүх материалыг эдгээр хичээлүүдэд багтаасан.

Суралцагчид ангид ирэхээс өмнө хичээл бүрийг уншсан байх ёстой. Хичээл бүрд 90-120 минут зарцуулах, дээр нь нэмээд хичээлээс гадуур хийх даалгавруудыг төлөвлөх хэрэгтэй. Энэ курс нь үндсэндээ практик үйл ажиллагаанд суурилсан учраас хичээлийг нэгээс олон уулзалтад хуваах боломжтой. Энэ нь суралцагчдад дасгал ажил хийх нэмэлт цаг хугацаа байх болно.

Ихэнх хичээлүүдэд тухайн хичээл дээр заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хэд хэдэн **үйл ажиллагаа** багтсан байгаа. Суралцагчдын хувьд эдгээр үйл ажиллагааг анхааралтай хийхэд хангалттай цаг гаргах нь чухал юм. Эдгээр дасгал ажлуудыг Бичвэрийн өөр өөр олон эшлэл дээр явуулна. Хичээлээ дуусгах гэж битгий яараарай. Эдгээр үйл ажиллагааны ихэнх нь суралцагчдын хувьд шинэ зүйл учраас ангид цаг гарган, суралцагч бүр дасгал ажлуудаа хэрхэн гүйцэтгэхийг ойлгосон эсэхэд анхаарал хандуулаарай. Гол зорилго нь тодорхой хариулт олж авах биш юм. Харин Библийг судалж, хөрвүүлэх чадвараа хөгжүүлэх нь үндсэн зорилго юм.

Курсын төгсгөлд суралцагч Бичвэрийн хэд хэдэн багц хэсгийг анхааралтай судалсан байх болно. Суралцагч бүр хичээлийн тэмдэглэлээ цаашид ашиглахын тулд компьютерт болон дэвтэртээ сайн хадгалах хэрэгтэй. Энэ курсээр хийсэн ажил нь номлол болон Библийн хичээл бэлтгэхэд тустай.

Хэлэлцүүлгийн асуултууд болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултуудын дагуу суралцагчдад хариултаа ярилцах боломж олгоорой. Суралцагч болгоныг хэлэлцүүлэгт оролцуулахыг хичээгээрэй. Шаардлагатай бол та суралцагчийг нэрээр нь дуудаж яриулж болно.

Суралцагч бүр курсын туршид нэг **курсын төсөл** дээр ажиллана. 10-р хичээлийн дараа тэд ангид танилцуулга хийх эсвэл ангийн удирдагчид бичгийн ажлыг хүлээлгэж өгнө. Танилцуулга болон бичгийн ажлын талаарх зааврыг 10-р хичээлийн даалгаврууд хэсэгт өгсөн байгаа.

2 болон 7-р хичээлийн төгсгөлд **бусад даалгавруудыг** багтаасан. Суралцагчид хийж гүйцэтгэсэн ажлаа ангийн удирдагчид үзүүлэх шаардлагатай бөгөөд харин ажлынхаа хуулбарыг өөртөө хадгалж авч үлдэнэ.